

2013 оны 06 сарын 17

A/239

Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр
гадаадад суралцуулах тухай

Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8.7 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн "Дэлхийн шилдэг сургуульд оюутан суралцуулах тухай" 2013 оны 78 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан "Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Баярсайхан овогтой Батцоожийг АНУ-ын Дартмоут дахь Массачусеттийн сургуулийн бакалаврын сургалтад физикийн чиглэлээр 4 жил, Дандарваанчиг овогтой Түвшинтөрийг Дартмоут дахь Массачусеттийн сургуулийн бакалаврын сургалтад компьютерийн шинжлэх ухааны чиглэлээр 4 жил, Сүхбат овогтой Машбаярыг АНУ-ын Лоуелл дахь Массачусеттийн их сургуулийн бакалаврын сургалтад биотехнологийн чиглэлээр 4 жил, Энхтайван овогтой Энхзаяаг АНУ-ын Висконсин-Мадисоны их сургуулийн бакалаврын сургалтад инженерийн чиглэлээр 2,5 жилийн хугацаагаар тус тус суралцуулсугай

2. Суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэлийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Мөнхцэцэг/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дээд боловсролын хэлтэс /П.Эрхэмбулган/-т тус тус даалгасугай.

Л.Гантөмөр

Л.ГАНТӨМӨР

ХУУЛБАР ҮНЭН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА *Л.Цэдэвсүрэн*
2013 оны 6 сарын 16 өдөр